

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамдинжав	Дугаар	L219
Оршин суугаа аймаг	Архангай	Оршин суугаа сум	Өлзийт сум
Төрсөн газар	Өлзийт сум	Төрсөн он	1949
Ажил мэргэжил	ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Оромбын доод хүрээ буюу Өөлд бэйсийн хүрээ	Сүм хийдийн дугаар	APӨЗ 070
Одоогийн сүм хийд	Алтан зуу хийд	Сүм хийдийн дугаар	APӨЗ 017
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

### Архангай аймгийн Өлзийт сумын Оромбын доод хүрээ буюу Өөлд бэйсийн хүрээ

Мөнхбат: За Архангай аймгийн Өлзийт сум бол Монголын дундад зууны түүх, ялангуяа 13-20-р зууны түүхэнд томоохон байр суурийг эзэлдэг. Ийм одоо түүхийн маш их онцлогтой газар нутаг, хүн ард, зон олон байгаа. Тэгэхээр Архангай аймгийн Өлзийт сум бол одоогийн байдлаар газар нутаг дэд бүтцийн хувьд төвийн эрчим хүчний системд холбогдсон, за УБ Мөрөнгийн чиглэлийн босоо замын тэнхлэг яг Өлзийт сумын зүүн талаар нь дайрч өнгөрдөг. Мөн өмнөд талаар нь УБ-аас Өгийнуур, Батцэнгэл цаашилбал Архангай аймгийн хойд чиглэлийн сумууд руу явах ийм замууд дайрч өнгөрдөг. Зам тээвэр дэд бүтцийн хувьд бол харьцангуй хөгжсөн ийм сум орон, газар нутаг. За түүх уламжлалын талаас нь аваад үзвэл Өлзийт сумын төв дээр өнөөдөр Өөлд бэйсийн хүрээ буюу академич Ренчин гуайн жагсаалтанд Оромбын доод хүрээ хэмээн нэрлэгдсэн энэ Өөлд бэйсийн хүрээ сумын төв дээр байрлаж байна. Тэгэхээр энэ Өөлд бэйсийн хүрээний түүхийг аваад үзэхээр лав нэг зуун тавь , жараад гаруй жилийн түүхтэй хүрээ юм байна лээ. За хүрээнд байсан энэ сүм дуган, дацангуудын барилга байгууламжийг үзэхэд харьцангуй 3-4 барилга байгууламжийн хана түүргэ бүрэн үлдсэн ийм байдалтай байна. Тэгэхээр бид нар энэ хүрээний түүх эх сурвалжийг ярилцахаар Өлзийт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга Дамдинжав гуайтай дараах ярилцлагыг хийсэн юм аа. Тэгэхээр энэ дашрамд хэлэхэд Дамдинжав гуай бол өөрөө түүхч, түүхийн багш мэргэжилтэй, за өөрийн нутаг орны хошуу нутгийн гарал үүслийн тухай, хөгжлийн тухай “ Өлзийт сумын түүхэн товчоо” гэсэн ийм номыг бичсэн. Энэ утгаараа энэ Өлзийтийн Өөлд бэйсийн хүрээ гэдгийг нэлээн судалсан ийм одоо эх сурвалжуудыг авсан ийм хүн юм. За ингээд таниас би дараах хэд хэдэн асуулыг асууя. Тэгэхээр бид нарын баримталж байгаа, манай судалгааны багийн баримталж байгаа энэ жагсаалтанд танай сумын хүрээ Ооромбын доод хүрээ буюу Өлзийтийн хүрээ гэсэн нэрээр нэрлэгдсэн байх юм. Тэгэхээр энэ хүрээний гарал үүсэл, байгуулагдсан анх шаваа тавьсан хугацаа,

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хаана тавьсан юм, одоо яг эндээ тавьсан юм уу, тэгээд нүүдэлчдийн соёлын дагуу тэр бууж, нүүдэллэж байсан цагуудыг тэр газар орныг ярьж хэлж өгнө үү?

Дамдинжав: За юуны өмнө судалгааны багт сумынхаа нийт иргэдийн өмнөөс мэндчилгээг уламжилж байна аа. За манай Өөлдүүд бол, Өлзийт сум бол түүх соёлоороо их онцлогтой. За мөн Өөлдүүд бол 1755-1757 онд Баруун Монголын эрх чөлөөний хөдөлгөөний дараагаар Өөлдийн гурван хошууг дотогш нь, Халхын нутаг руу татаж оруулж ирсэн ийм эх сурвалж байдаг юм байна лээ. За 1761 онд Өөлдийн одоо 3 хошуунд болвол одоогийн Говь-Алтай аймгийн Шарга сум, Архангай аймгийн Хотонт сум буюу Сүсэгт бэйсийн хошуу. За үүнийг бол яахав Өөлдийн умард хошуу гэж нэрлэдэг. Мөн одоо энэ Өөлдийн өмнөд хошуу, Өөлдийн умард хошуу буюу Өөлд бэйсийн хүрээний 1761 онд энд нутагшуулсан гэж тэмдэглэдэг юм аа. Тэгээд дайны хөлд явж байсан энэ ард түмэн болвол гучаад жилийн дараа буюу 1797 онд Өөлд бэйсийн хүрээний анхны суурийг одоогийн Бодонт багийн нутаг Олст уулын өвөрт тэнд байгуулж ингээд 13 жил болсон гэж нутгийн хөгшчүүд ярьдаг. За үүний туурь энэ тэр бол тэндээ хадгалагдаж байдаг. За энэ Олст уулыг бол нутгийн зарим иргэд тахидаг ийм уламжлал бий. За эндээс 13 жил болчихоод дээшээ одоо Норжин жинбаа уулын дундах Рашаантын баруун зүүн салааны бэлчир дээр Өөлдийн өвгөн хүрээ гэж байгуулагдаж 33 жил тэнд суурьшсан байгаа юм. Тэгээд энэ их хүрээнд байсан хугацаанд бол тэр тухайн хошуунд бас хүрээ хийдэд их хэмжээний халуун ханиад, өвчин зовлон гарсан тул эндээс нүүх нь зүйтэй гэсэн төлөг мэргэчдийн зурхай гарч хошуу нутгийн нэртэй зурхайч Данзан гэдэг хүн цагаан сарын хуучдаас зуны эхэн сар хүртэл газар нутгийг шинжин үзэж одоогийн Өлзийт сумын оршиж байгаа энэ нутаг буюу Өөлд бэйсийн хүрээ оршиж байгаа энэ нутгийг сонгон авсан ийм түүхтэй. За энэ хошууны ерөнхий энэ нутгийн шинж бол 60 жилийн жавар хүралдсан чөтгөр тогтохгүй хүйтэн газар тул хошуу нутагт олныг хамарсан халуун ханиад, янз бүрийн өвчин зовлон ирэхгүй гэж энэ зурхайд буусан байдаг юм байна лээ. Тэгээд одоо Рашаантын хүрээнээс энд ирж суурьшихдаа 1843 оны үед ирж энд газар нутаг үзэж. Тэгээд энд одоо яахав гэхлээр хошуу ноён өөрийнхөө сүм хийдийг, орд харшийг энд барих юм бол ард нь түм хүрэх гээд байдаг. Шар тал нь буюу лам нь сүм хийдээ барих гэвэл шавь нь түм хүрэх гээд байдаг. Ийм одоо маргаан үүссэний эцэст нөгөө хийд нь хоёр хэсэг болж салж нүүсэн. Нэг хэсэг нь яахав гэхээр тэр Ооромбо гэгээний хийд буюу одоогийн Өгийнуур сумын хойно Баясгалант уулын өвөрт тэр газар Ооромбо гэгээний дээд хүрээ байгуулагдаж гол их хүрээ нь энд үлдсэн ийм түүхтэй. 1843-1910-аад оны үед энэ төв байгаа сумын нутагт маш олон сүм хийд байсан юм байна. За одоо байж байгаа жүдийн дуган байна, чойрын дуган байна, цамын байшин байна, за нураагаад аваад явчихсан, нурчихсан дордгын дуган, дарь эхийн дуган, зуугийн сүм, за хоёр гурван жас байсан байгаа юм. Зуугийн жас гэж одоо их том мал хөрөнгөтэй, чинээлэг жас байсан байна. За мөн чойрын жас гэж байсан ийм одоо сүм дуган байж байгаад үйл ажиллагаа нь бол 1920-оод он хүртэл, 1930-аад он хүртэл идэвхитэй явагдаж байгаад бас л сүм хийд лам нарын асуудал төвөгтэй болсон учир хаагдаад тэгээд шинэ эргэлтийн засгийн үед бодлогын үед ахин хурал ном сэргэж 1933, 1934 онд хурал ном явагдаж байгаад ахин хэлмэгдлийн үед бол 1937-1940 оны үед бол хүрээ хийд үндсэндээ бол эзэнгүйрч байсан юм байна лээ. Лам нар нь баривчлагдсан, тэгээд нийтдээ одоо лам хувраг, төрийн алба хашиж явсан нийтдээ 100 гаруй хүн

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бол манай сумаас , дээд хүрээнээс Ооромбо гэгээний хүрээнээс бас хэд билээ. Нийлээд нэг 100 гаруй хүн бол бас энэ хэлмэгдэлтэнд өртсөн ийм сурвалж байдаг юм.

Мөнхбат: Тэгэхээр та түрүүн бас яриандаа хэлж байсан. Ооромбо гэгээн, бид нар бол Ооромбо гэж бичээд байгаа. Энэ бол Түвд хүн байсан гэж ярьж байсан тийм ээ. За дээрээс нь шашин номынхоо яг хөгжил цэцэглэлтийн үед Ооромбын хүрээ буюу энэ Өөлд бэйсийн хүрээ хичнээн лам хуврага сууж байсан юм бол, гол шүтээн сахиус нь юу байсан юм бол энэ талаар бас товчхон хэлж өгнө үү?

Дамдинжав: За Ооромбо гэдэг бол яахав гэхлээр бас Түвд хүн л дээ, гэгээн гэдгээр тодорч байсан. Монголд залагдаж манай энэ Өөлдийн хүрээнд залагдаж байсан. Мөн Гачин лам гэж хүн ирж байсан хүн байна лээ. Энэ нь одоо яахав гэхлээр Өөлдийн их шүтээн Алтанзуу бурхны тахилч ламаар ирж байсан гэдэг юм аа. Энэ хүний одоо хамгаалалтын олбог молбог олон хүнд ирж байсан юм байна лээ. Ооромбо гэгээний хийд, за хийддээ бол яахав гэхлээр хоёр хүрээ нийтдээ 400 гаруй ламтай байсан болов уу даа гэсэн ийм таамаглал байгаа. Зүгээр яг нарийн тоо бол одоохон.доо бас байхгүй байна л даа.

Мөнхбат: Тэгэхээр 1937-1939 оны үед явагдсан тухайн үеийн төр нийгмийн энэ бурунгүй бодлогын үрээр Монголын буддын шашны томоохон хүрээ хийдүүд, лам нар хэлмэгдсэн. Тэгэхээр харьцангуй бас манай судалгааны багийн явсан газраас бүрэн бүтэн гэдэг утгаараа хэдийгээр одоо 16, 17 сүмээс 2, 3 нь үлдсэн ч гэсэн хана туурга нь байж байгаа энэ хүрээ хийд бол энэ Өөлд бэйсийн хүрээ юм аа.Тэгэхээр Өөлд бэйсийн хүрээ 1937, 1938 онд шатаагдаад дуусчихаагүй бас одоо үлдэгдэл юм нь байсан, барилга байгууламжууд гэж та түрүүн ярьж байсан, мэдээллэж байсан.Энд одоо тэр 1940, 1950, 1960-аад оны үед бол тухайн үеийн хөдөө аж ахуйн нэгдлийн үед энэ барилга байгууламжийг ямар хэлбэрээр ашиглаж байсан юм, тэгж одоо хамгаалж байсан байдаг юм уу, эсвэл одоо аж ахуйн хэрэгцээнд ашиглаж байгаад тэгээд хүмүүс буулгаж хурааж авсан байдаг юм уу, энэ талын түүхийг нь та яривал?

Дамдинжав: За баярлалаа. Тэгэхээр нэлээн хэдэн барилга байгууламжууд үлдсэн байдаг юм аа. Энэ нь яахав гэхлээр бидний одоо тэр бага насны дурсамжинд үлдсэн байдаг. Жишээлэх юм бол чойрын дуган бол уг нь давхар оройтой байсан юм байна лээ. Тэгэхээр энэ оройг нь авчихаад тал тал тийш нь модон цорготой, борооны үс нь тэгээд гадагшаагаа урсдаг ийм сайхан барилга байсан. За энийг бол яахав гэхлээр тухайн үеийн худалдаа бэлтгэлийн анги, түүхий эдийн скаладаар 1940-1990-ээд оныг хүртэл ашигласан. Жүдийн дуганыг болвол мөн худалдаа бэлтгэлийн анги хүнсний барааны скаладаар ашиглаж байсан. За цамын дуган байшин бол яахав гэхлээр бид нарыг жоохон байхад зарим нэгт нь дэлгүүр, контор нь байсан. Сүүлдээ өлөнгийн савалгааны цех болж хувирсан л даа. За энэ цамын дуганаас зүүн тийшээ бас нэг гучаад км хэртэй ийм цагаан хэрэм, лонж гээд яриад байдаг байсан юм аа. Бас нэг жижигхэн суварга шиг цагаан юм, дотор нь бас одоо бууны сүм, тэсрэх бодис, дарь мариа хийчихдэг. Бууны сүм, ийм л одоо худалдаа бэлтгэлийн анги ийм л чиглэлээр ашиглаж байсан. За тэр шинэ баригдсан тэр дуганы хойд талд байгаа маналын дуган гэдэг бол яахав, бас тэр сүү тосны заводын байшин, бас нэлээн хэдэн байшин байсан, модон чигтээ. Ардаа бас мөсөн зоорьтой. Тэгээд тэр мөсөн зоорийг яахав гэхлээр 1939 оны дайны дараагаар олзны японуудаар ухуулж хийсэн гэдэг юм л

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

даа. Тэгээд энд сүү тосны завод хийж байсан, ашиглаж байсан. Тэр сургуулийн хашаанд байсан Зуугийн жасын байшин болвол хүрэн байшин гэж нэг их сайхан байшин байсан даа. Энийг бол дээр үед сумын клубээр ашиглаж байсан, сургуулийн дотуур байр, сургуулийн скалад за тэгээд дагалдах хэд хэдэн байшин байсан юм, контор монтор бас скалад байж байгаад тэгээд сүүлд явах үед нь нураад ингэж ашиглаад ингээд үлдэж байгаа нь энэ гурван сүмийн одоо байдал л байна даа. Тэгээд нийтдээ хараад явах юм бол их олон, олон сүм хийдийн байшин байж байгаа ш дээ. Ийм л одоо юм байна.

Мөнхбат: За 1990 онд бурхны шашин дахин мандан бадрах тэр цаг үед Өлзийт сумынхан Өөлд бэйсийн хүрээгээ сэргээсэн тухай ярьж өгнө үү?

Дамдинжав: 1987, 1988 оны үед суманд анх удаа соёлын сан гэж байгуулагдсан. Түүнийг манай өндөр настан Чимэдбазар гуай ахалж байсан. Тус сан түүх соёлын дурсгалаа харж хамгаалах энэ үлдсэн сүм дуганаа сэргээх зорилготой гарч ирсэн. Энэ сангийн үйл ажиллагаа явсаар байгаад 1990 онтой золгож улмаар лам хөгшид нийлсэн 13 хүний санаачилгаар нэгдлээс нэг гэр авч анхны гэр дуганыг байгуулж анхны хурлаа хийсэн.Тэгээд явсаар байгаад Өөлд бэйсийн хүрээ бол ийм байж болохгүй юм гэж үзээд сумын төр захиргаа ард иргэд сүсэгтэн олон хамтран манай тэр өндөр настан Чимэдбазар, тэр хамба байсан залуу Бат-Орших нар гол санаачилгыг гаргаж 2000 онд энэ Алтанзуу хийдийн гол дуганыг байгуулсан. 13/10 метрийн том модон дуганыг барьж дотор талыг нь бурхны судар ном, эдлэл хэрэглэгдэхүүнийг ард түмэн, сүсэгтэн олон төр засгийн удирдлагууд хүртэл хамтран хандивлаж өгсөн. Тухайлбал, монгол улсын ерөнхийлөгч асан Багабанди гуай 1999, 2000 онд манай суманд томилолтоор ажилласан л даа. Тэгэхдээ Балбын хаант улсаас бэлэглэсэн тэр алтан дарь эх бурхныг өгсөн. Гомбо сахиус ганжуурын 108 боть, улаан юм зэрэг ном судартай болсон. Ер нь барилга байшин, эдлэл хэрэглэгдэхүүний хувьд хаана ч очсон нүүр улайхааргүй болсон. Манай сүмийн гол шүтээн бол Алтанзуу бурхан. Түүхэнд монголд шарын шашин дэлгэрэхэд Баруун Монголын Өөлдүүд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Алтанзуу бурхан Төрбайх хааны хүсэлтээр Далай лам бүтээж баг цэргээр хамгаалаалуулан 1640, 1650-аад оны үед ирж байсан гэсэн домогтой.Ингээд явсаар байгаад 1930-аад оны үед жинхэнэ Алтанзуу бурхан алга болчихсон.Ингээд 1998 оныг хүртэл Алтанзуу бурхангүй байж байгаад манай тэр өвгөн лам Чимэдбазар гуай санаачлан ард олныг уриалан Алтанзуу бурхнаа бүтээлгэсэн юм. Үүнээс хойш хаврын тэргүүн сарын 15-нд Алтанзуу бурхны мөргөл гэж том мөргөл болдог.Бүтэн 15 хоног тасралтгүй буяны ном хурдаг. Бас бэсрэг наадам болдог. Намрын дунд сарын 15-нд бас мөргөл болдог.Ер нь цаашдаа Өөлд бэйсийн хүрээ Алтанзуу хийдийг сэргээх, шинэчлэх тухай асуудал манай сумын ард түмний гол хүсэл мөрөөдөл байдаг.Энэ бол зөвхөн Өлзийт сумынхны хэрэг биш Монголын ард түмний соёл, уламжлал юм. Бид зүгээр байгаагүй. 1999, 2000 онд Монгол улсын ерөнхийлөгч Багабанди, 2001 онд БСШУ-ны яамны дэд сайд асан Эрдэнэсүрэн нарт удаа дараа хандсан. Үүний хүчинд 2001 оны 5-р сард соёлын өвийн сангийн захирал Бямбажав гуай өөрийн биеэр ирж газар дээр нь байдалтай танилцаад дараа нь Сүлд-Уул компаний мэргэжилтнүүд ирж 10 гаруй хоног ажиллан зураг төсөл, төсөв хөрөнгө зэргийг тооцож гаргаад 250 сая төгрөг хэрэгтэй гэсэн тооцоог хийж зураг төслөө хийгээд буцсан.Ингээд энэ мөнгө дараа оны улсын төсөвт орсон

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тохиолдолд сэргээн босголт хийгдэнэ гэж яригдсан боловч энэ яриа замхарсан. Ингээд бүр сураггүй болмогц бид энэ өнгөрсөн 1-р сард ерөнхийлөгч Н. Энхбаярт хандан албан бичиг тоот 428 хүний гарын үсэг бүхий хүсэлт хүргүүлчихээд сууж байна. Ер нь Өлзийт сум дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, энэ гүүрийг дагаад УБ-Мөрөнгийн босоо тэнхлэгийн зам дайрч өнгөрдөг. Мянганы замын хэвтээ тэнхлэг Хархорины чиглэлд манай урдуур хориодхон км-т өнгөрч Өлзийт сум өөрөө түүх соёлын дурсгалаар баялаг төдийгүй хажууханд дэлхийн соёлын өвд орсон Орхоны хөндийн соёл, Хөшөө цайдам байж байгаа зэрэг таатай нөхцөл боломжуудыг түшиглэн энэ буддын үлдсэн сүм дугануудыг л сэргээн босгох шашны соёл, аялал жуулчлалын үзмэр болгох талаар төр засаг анхаарах ёстой. Үүнийг сэргээн босгох явдал бол манай сумын ард түмний үнэхээрийн эрхэм зорилго юм.

Мөнхбат: Таньд баярлалаа.